

Геологийн мэдээллийг цахимаар авах боломж бүрдлээ

Б.БОЛОРЦЭЦЭГ, [HTTP://WWW.IKON.MN/N/1321](http://WWW.IKON.MN/N/1321)

2017 ОНЫ 8 САРЫН 18



Геологийн мэдээ мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэн, хэрэглэгчдээд түргэн шуурхай бодитоор хүргэх боломжтой Монголын геокат системийг энэ оны дөрөвдүгээр улиралд нэвтрүүлэх болсон талаар өнөөдөр Ашигт Малтмал, Газрын Тосны Газраас мэдээллээ.

Энэ талаар албаны хүмүүс байр сууриа илэрхийллээ

АМГТГ-ЫН дарга Б.Баатарцогт "Энэ Монголын геокат систем нь Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Жон Лангрейвиг бүрдүүлсэн томоохон ажил юм.



Гэрэл зурсгийг тра.mn

Тиймээс энэ цахим үйлчилгээг орчин үеийн технологи дээр суурилуулан байгуулах ажилд гүн туслалцаа үзүүлсэн Австрали Улсын Засгийн Газар, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам болон бүхий л хамтарч ажилласан хүмүүстээ талархал илэрхийлье" гэсэн юм.

Австрали Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Жон Лантри "Монголын Болон олон улсын ажилтан тэр дундаа Австралийн геологичид хамтраад энэхүү системийн дизайн, төлөвлөгөөг гаргаж үүндээ шаардлагатай программ хангамж, техник хангамжуудыг худалдан авах ажиллах хүмүүсээ сурган авах зэрэг ажлыг хөтөлбөрийн хүрээнд хийж гүйцэтгэсэн.



Олон улсын туршлагаас харахад геологийн мэдээллийг ийм хүртээмжтэй болгосноор геологийн хайгуулын салбарт учрах эрсдэлийг бууруулахын зэрэгцээ гадаад дотоодын хөрөнгө оруулалтыг татахад маш их хэрэгтэй байдаг гэдгийг онцлон хэлмээр байна.

Монгол Улсын хувьд ашигт малтмалын баялгаа зүй зохистой ашиглах, эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх зүй зохистой ажил болж байна" гэлээ.

МонГеоКат систем нь Эрдэс Баялгийн Мэдээллийн Технологийн Төв-д буй геологийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд хүргэх зорилготой, 2 бүрэлдэхүүн хэсэгтэй нэгдсэн систем бөгөөд геологийн мэдээллийн эх үүсвэрийн талаарх хураангуйг мэдээллийг өгөх юм.

ГЕОЛОГИЙН МЭДЭЭЛЛИЙГ ХҮРТЭЭМЖТЭЙ БОЛГОСНООР ГАДААД ДОТООДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ТАТДАГ

УУХУЯ-ны Төрийн Нарийн Бичгийн Дарга Г.Нандинжаргал " Төрөөс Эрдэс Баялгийн салбарт баримтлах бодлого, болоод ашигт малтмалын тухай хуульд үндэсний геологи эрдэс баялгын санг олон улсын жишигт хүргэхүйц орчин үеийн программ хангамж болон техникийн шийдэлтэйгээр бүрдүүлж баяжуулна гэж заасан байдаг.

Үүний дагуу үе үеийн Геологичдын нөр их хөдөлмөр тэр их мэдээллийн санг ийнхүү нэгтгэн олон нийтэд нээлттэй болгож байгаад үнэхээр талархаж байна" гэсэн юм.

Энэхүү системийн талаар **Оюуны Цоморлиг ХХК-ын зөвлөх Д.Амарсайхан** "МонГеоКат системийн 1-р бүрэлдэхүүн хэсэг нь цахим сүлжээний орчинд орон зайн хайлт хийх боломжтой газарзүйн мэдээллийн систем бөгөөд уг систем нь орон зайн дүн шинжилгээ хийдэг ArcGIS програмд суурилсан.

2-р бүрэлдэхүүн хэсэг нь геологийн мэдээллийн тухай хураангуйг түлхүүр үгээр хайх метадата-каталоги систем бөгөөд энэ нь орон зайн мэдээллийн каталоги хийхэд хэрэглэдэг GeoNetwork програмд суурилсан.

Метадата гэдэг нь ямарваа мэдээллийн талаарх хураангуй мэдээ бөгөөд тухайн мэдээллийг хэн, хэзээ, хаана, хэрхэн, ямар зорилгоор бэлтгэсэн талаар өгүүлдэг" гэж танилцуулсан юм.

Хэрэглэгч МонГеоКат системээс дараах мэдээллийг хайх боломжтой.
Үүнд:

- Веб ГМС-ийн орчинд орон зайн хайлт хийж, төрөл бүрийн суурь зураг, жижиг, дунд масштабын геологийн зургууд, сансрын зураг, ашигт малтмалын ордуудын байршил, Google-ын суурь зургууд болон бусад мэдээлэл
- Метадата-каталоги системээс олон сонголтот хэрэгсэл ашиглан хайлт хийж, мэдээллийн тухай хураангуй буюу уг мэдээллийн зохиогч, эзэмшигч, хэмжээ, хэлбэр, хэлний сонголт, бусад мэдээлэлтэй хэрхэн

холбогддог, хайгуултай холбоотой мэдээлэл, байрзүйн холболттой эсэх, хандалтын зэрэглэл болон бусад мэдээлэл.

Англи, Монгол хэл дээрхи энэхүү системийг интернетэд холбогдсон дурын хэрэглэгч www.geonet.mris.mn болон www.webgis.mris.mn цахим хуудсанд хандан ашиглах боломжтой.